



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 08 сарын 10 өдөр

Дугаар 2/31

Улаанбаатар хот

Үүрэг даалгавар биелүүлэх тухай

Эрүүл мэндийн сайдын 2016 оны 8 сарын 4-ний хурлаар өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ТУШААХ нь :

1. Байгууллагын нийт ажилтан, албан хаагчид өөрсдийн хариуцсан үйл ажиллагаатай холбоотой үргүй зардлыг багасгах тал дээр санаачлагатай ажиллан, гарсан хэмнэлтийн талаар сар тутам мэдээллэж байхыг албадын дарга, тасгийн эрхлэгч нарт, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Гүнжээ/-д үүрэг болгосугай.
2. Донорын сургалт, сурталчилгааны ажлын материалыг шинэчлэх үүнд ард, иргэдэд эрүүл аж төрөх ёсны сургалт, өвчинеөс урьдчилан сэргийлэх талаар үр дүнтэй ажлуудыг зохион байгуулахыг Донор элсүүлэлт, маркетингийн нэгж /Д.Наранхүү/, Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч /Ч.Тунгалаг/ нарт тус тус даалгасугай.
3. Нийт ажиллагсдыг ажлын байрны сургалт, мэргэшүүлэх сургалт, дадлагажуулах сургалтын төлөвлөгөөг тодотгон шинэчлэх, хүний нөөцийн чадавхийг сайжруулах, ажлын бус цагаар сургалт зохион байгуулахыг Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны албаны дарга /Б.Цогбадрах/-д даалгасугай.
4. Нийт эмч, ажиллагсдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах, үйлчлүүлэгчдэд таатай орчин бүрдүүлэх, ажлын байрны сахилга хариуцлагыг сахин ажиллахыг төвийн нийт ажиллагсадад, хяналт тавьж 7 хоног бүр мэдээллэж байхыг харьяалах албадын дарга, тасгийн эрхлэгч нарт тус тус даалгасугай.

5. ЭМЯ-наас хүлээлгэн өгсөн 2 агааржуулагчийг цус, цусан бүтээгдэхүүн хадгалах өрөөнд суурилуулан, богино хугацаанд үйл ажиллагаанд оруулах, тоног төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээнд анхаарч ажиллахыг Мэдээллийн технологи, инженер техникийн тасгийн эрхлэгч /Ч.Далайцэрэн/-д даалгасугай.
6. Төвийн болон орон нутгийн Цусны салбар төвийн үндсэн үйл ажиллагаанд дотоод хяналтыг сайжруулах, тусlamж үйлчилгээний чанар, аюулгүй бийадлыг хангаж ажиллахыг Чанар, цусны сонор сэрэмжийн албаны дарга /Т.Алимаа/-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР